



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/183/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Арвайхээр 2022 он</p>	<p>Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com Аудитор: Э.Энхбаяр П.Норпил Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn Norpilp@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Аудитын тайлан
- 3.1 Ерөнхий зүйл
- 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Материаллаг байдал
- 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
- 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг
- 3.8 Аудитын гол асуудал
- 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал
4. Аудитын илрүүлэлт
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв

1. Аудитын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээ, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.02.08 № 105
танай _____-ны № _____-т

БҮСИЙН ОНОШИЛГОО
ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Э.ХҮДЭРЧУЛУУН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тарагт сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barim\A4

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	823,054,676.75	1,558,538,723.05
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	1,163,400.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	1,163,400.00
3121	Төгрөг	00.00	1,163,400.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	1,163,400.00
33	АВЛАГА	62,511,754.00	752,977,640.70
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	903,074.00	1,025,360.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	751,952,280.70
33300	Татаас, санхүүжилтийн авлага	61,155,500.00	00.00
335	Бусад авлага	453,180.00	971,153.13
3351	Байгууллагаас авах авлага	453,180.00	971,153.13
35	БАРАА МАТЕРИАЛ	760,542,922.75	803,426,529.22
351	Түүхий эд материал	274,423,711.89	311,471,312.64
35130	Эм боох материал	274,423,711.89	311,471,312.64
354	Хангамжийн материал	486,119,210.86	491,955,216.58
35410	Бичиг хэргийн материал	3,991,500.00	3,266,650.00
35420	Аж ахуйн материал	10,400.00	52,400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,848,541.35	3,498,541.35
35440	Түлш, шатах тослох материал	3,680,000.00	1,257,000.00
35450	Барилгын засварын материал	10,628,240.00	4,204,380.00
35460	Хүнсний материал	517,655.14	1,904,800.05
35470	Бусад хангамжийн материал	463,442,874.37	477,771,445.18
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,703,379,934.83	14,854,381,233.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,703,379,934.83	14,854,381,233.87
392	Биет хөрөнгө	11,980,026,601.51	14,098,587,900.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,792,791,290.00	8,792,791,290.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-322,167,515.37	-529,088,995.41
39203	Авто-тээврийн хэрэгсэл	674,377,386.37	674,377,386.37
39204	Хуримтлагдсан элэгдэл	-441,348,261.31	-499,062,975.35
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7,434,464,285.34	11,017,892,235.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,273,118,687.70	-5,480,056,955.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	438,335,189.55	486,510,189.55
39208	Хуримтлагдсан элэгдэл	-323,307,085.37	-364,774,274.62
393	Биет бус хөрөнгө	723,353,333.32	755,793,333.32
39301	Програм хангамж	2,685,000.00	2,685,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,691,666.68	-1,931,666.68
39303	Бусад биет бус хөрөнгө	722,360,000.00	755,040,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	13,526,434,611.58	16,412,919,956.92
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	60,260,000.00	1,450,972,695.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	60,260,000.00	1,450,972,695.00
413	Өглөг	60,260,000.00	1,450,972,695.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	113,251,478.00
4136	Бусад өглөг	60,260,000.00	1,337,721,217.00
41361	Байгууллагад төлөх өглөг	60,260,000.00	1,336,292,217.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	1,429,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,466,174,611.58	14,961,947,261.92
51	Засгийн газрын хувь оролцоо	13,466,174,611.58	14,961,947,261.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,155,889,148.59	6,155,889,148.59
51101	Өмч: - төрийн	6,155,889,148.59	6,155,889,148.59
512	Хуримтлагдсан үр дүн	2,910,265,166.27	4,406,037,816.61
51210	Өмнөх үеийн үр дүн	2,910,265,166.27	2,910,265,166.27
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,495,772,650.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,400,020,296.72	4,400,020,296.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	13,526,434,611.58	16,412,919,956.92

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	12,372,377,327.47	18,470,633,704.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,534,309,934.47	5,617,193,421.47
120	Нийтлэг татварын бус орлого	414,753,648.00	2,039,831,631.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	414,753,648.00	2,039,831,631.86
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	194,714,000.00	201,019,800.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		751,952,280.70
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	220,039,648.00	1,086,859,551.16
122	Тусламжийн орлого	1,119,556,286.47	3,577,361,789.61
122001	Хандив тусламж /дотоод/	1,119,556,286.47	3,577,361,789.61
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,838,067,393.00	12,853,440,283.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,420,836,400.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,300,316,400.00	00.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	120,520,000.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,416,500.00	1,417,415,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,004,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	874,140,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,412,500.00	543,275,000.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	1,250,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	00.00	1,250,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,346,814,493.00	10,186,025,283.30
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	4,346,814,493.00	10,186,025,283.30
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	11,547,256,113.22	16,974,861,054.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,547,256,113.22	16,974,861,054.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,479,580,613.22	16,427,361,054.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,435,056,037.00	7,998,982,781.00
210101	Үндсэн цалин	2,976,047,052.00	3,307,796,699.00
210102	Нэмэгдэл	2,760,711,995.00	3,939,299,482.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	239,088,309.00	255,717,000.00
210104	Урамшуулал	459,208,681.00	496,169,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	864,175,259.00	1,050,598,008.57
210201	Тэтгэврийн даатгал	627,027,956.00	903,956,878.57
210202	Тэтгэмжийн даатгал	59,286,851.00	36,660,533.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	47,354,270.00	29,273,066.00
210204	Ажилгүйдлийн даатгал	12,614,944.00	7,386,966.00
210205	Эрүүл мэндийн даатгал	117,891,238.00	73,320,565.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	524,988,457.00	00.00
210301	Гэрэл, цахилгаан	128,790,281.00	00.00
210302	Түлш, халаалт	309,946,560.00	00.00
210303	Цэвэр, бохир ус	86,251,616.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	165,748,039.20	189,005,289.00
210401	Бичиг хэрэг	13,809,535.00	15,270,420.00
210402	Тээвэр, шатахуун	73,785,500.00	80,423,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,637,686.00	11,181,682.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	54,926,990.00	65,059,397.00
210406	Бага үнэтэй, тургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,588,328.20	17,070,790.00

Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	2,077,855,221.85	4,810,489,154.29
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,796,367,444.90	4,263,272,298.40
210502	Хоол, хүнс	225,894,286.95	487,138,699.69
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	55,593,490.00	60,078,156.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	105,092,479.24	100,400,760.00
210604	Урсгал засвар	105,092,479.24	100,400,760.00
2107	Томилолт, зочны зардал	12,731,200.00	00.00
210702	Дотоод албан томилолт	12,731,200.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,321,571.00	13,307,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	27,639,800.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,670,400.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	788,028.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	253,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,389,793.00	00.00
210807	Газрын төлбөр	282,600.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,721,950.00	13,307,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,237,612,348.93	2,264,577,311.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,282,309.00	751,295,660.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,229,330,039.93	1,513,281,651.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,675,500.00	547,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,520,000.00	547,500,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	547,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,520,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	61,155,500.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,155,500.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	825,121,214.25	1,495,772,650.34
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,152,987.02	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	10,152,987.02	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-10,152,987.02	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	814,968,227.23	1,495,772,650.34

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

АУДИТЛАГДСАН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр /
						Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,155,889,148.59	4,400,020,296.72	2,910,265,166.27	00.00	13,466,174,611.58
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,155,889,148.59	4,400,020,296.72	2,910,265,166.27	00.00	13,466,174,611.58
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,155,889,148.59	4,400,020,296.72	2,910,265,166.27	00.00	13,466,174,611.58
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууцалт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,495,772,650.34	00.00	1,495,772,650.34
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,155,889,148.59	4,400,020,296.72	4,406,037,816.61	00.00	14,961,947,261.92

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	10,972,521,393.00	13,115,615,583.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	194,714,000.00	261,279,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	194,714,000.00	261,279,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	194,714,000.00	261,279,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	194,714,000.00	201,019,800.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		60,260,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,777,807,393.00	12,854,335,783.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,360,576,400.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,300,316,400.00	00.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	60,260,000.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,416,500.00	1,418,310,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,004,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	874,140,000.00
131104	Дрэд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,412,500.00	543,275,000.00
131107	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих - Нэмэлт		895,500.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	1,250,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	00.00	1,250,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,346,814,493.00	10,186,025,283.30
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	4,346,814,493.00	10,186,025,283.30
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	10,216,875,935.00	13,056,477,183.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,216,875,935.00	13,056,477,183.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,149,200,435.00	12,508,977,183.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,435,056,037.01	7,588,116,248.70
210101	Үндсэн цалин	2,976,047,052.01	3,307,796,699.70
210102	Нэмэгдэл	2,760,711,995.00	3,528,432,949.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	239,088,309.00	255,717,000.00
210104	Урамшуулал	459,208,681.00	496,169,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	863,793,489.99	1,349,977,151.00
210201	Тэтгэврийн даатгал	626,646,186.00	1,092,464,266.00
210202	Тэтгэмжийн даатгал	59,286,851.00	64,378,222.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	47,354,270.00	50,914,145.00
210204	Ажилгүйдлийн даатгал	12,614,944.72	13,464,076.00
210205	Эрүүл мэндийн даатгал	117,891,238.27	128,756,442.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	524,988,457.00	00.00
210301	Гэрэл, цахилгаан	128,790,281.00	00.00
210302	Түлш, халаалт	309,946,560.00	00.00
210303	Цэвэр, бохир ус	86,251,616.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	172,790,259.00	00.00
210401	Бичиг хэрэг	15,952,873.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	77,465,500.00	00.00
210403	Шүүдан, холбоо, интернэтийн төлбөр	8,667,686.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	53,948,100.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,756,100.00	00.00
2105	Нормативт зардал	1,959,175,415.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,678,575,491.00	00.00
210502	Хоол, хүнс	223,345,874.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	57,254,050.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	112,089,170.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,766,800.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,220,000.00	00.00
210604	Урсгал засвар	91,102,370.00	00.00
2107	Томилголт, зочны зардал	12,731,200.00	00.00
210702	Дотоод албан томилголт	12,731,200.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,294,098.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,639,800.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,670,400.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	788,028.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	253,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,359,670.00	00.00
210807	Газрын төлбөр	282,600.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	18,724,600.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,282,309.00	3,570,883,783.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,282,309.00	3,570,883,783.60

**Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,282,309.00	3,570,883,783.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,282,309.00	3,570,883,783.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,675,500.00	547,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,520,000.00	547,500,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	547,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,520,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	61,155,500.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,155,500.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	755,645,458.00	59,138,400.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	755,645,458.00	57,975,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	755,645,458.00	57,975,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	755,645,458.00	57,975,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	755,645,458.00	57,975,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-755,645,458.00	-57,975,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	1,163,400.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	1,163,400.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	00.00	00.00	12,248,470,000.00	12,095,129,683.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	00.00	12,248,470,000.00	12,095,129,683.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	00.00	12,248,470,000.00	12,095,129,683.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	00.00	7,490,044,100.00	7,490,044,099.70
210101	Үндсэн цалин	00.00	00.00	3,307,796,700.00	3,307,796,699.70
210102	Нэмэгдэл	00.00	00.00	3,430,360,800.00	3,430,360,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00	255,717,000.00	255,717,000.00
210104	Урамшуулал	00.00	00.00	496,169,600.00	496,169,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	00.00	1,337,626,300.00	1,337,626,300.00
210201	Тэтгэврийн даатгал	00.00	00.00	1,084,036,300.00	1,084,036,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	63,397,500.00	63,397,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	50,718,000.00	50,718,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	12,679,500.00	12,679,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	126,795,000.00	126,795,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	3420799600.00	3267459283.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00	3,420,799,600.00	3,267,459,283.60
	ЗАРДЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00	12,248,470,000.00	12,096,293,083.30
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	00.00	1,250,000,000.00
132001	Орон нутгийн төсвөөс				
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС	00.00	00.00	12,080,507,600.00	9,785,013,283.30
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00	12,080,507,600.00	9,785,013,283.30
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	00.00	00.00	167,962,400.00	261,279,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00	167,962,400.00	201,019,800.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	00.00	00.00	00.00	60,260,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	1,163,400.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	00.00	00.00	369.00	443.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	316.00	390.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	52.00	52.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

АУДИТЛАГДСАН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,019,322,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,019,322,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		471,822,500.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		98,072,149.00
210102	Нэмэгдэл		98,072,149.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		12,350,851.00
210201	Тэтгэврийн даатгал		8,427,966.00
210202	Тэтгэмжийн даатгал		980,722.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		196,145.00
210204	Ажилгүйдлийн даатгал		784,576.00
210205	Эрүүл мэндийн даатгал		1,961,442.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		9,915,000.00
210602	Тавилга		9,915,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	351,484,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		351,484,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	547,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		547,500,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		547,500,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	618,310,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		618,310,500.00
131101	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		401,012,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тусуу		74,140,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шат		543,275,000.00
131105	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		895,500.00
131106	Төсвийн урамшуулал		
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Э.Энхбаяр, П.Норпил нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аймгийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 30 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн “Үйлчлүүлэгчдэд ээлтэй, нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээг чанартай үзүүлэхэд оршино” эрхэм зорилготой, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль тогтоомжид нийцүүлэн 8 зорилтыг хэрэгжүүлэх, иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, цаг алдалгүй хүргэх, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгаа явуулах, батлагдсан төсвийг хуульд заасны дагуу зарцуулах, тусламж үйлчилгээний чиглэлээр 37 арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэсэн байна.

Тайлант хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

БОЭТөвийн захирлын тушаалаар дотоод хяналтын ажлын хэсгийг жил бүр шинэчлэгдэн батлуулж, мөрдөн ажилладаг байна. Дотоод хяналт шалгалтын жилийн ажлын төлөвлөгөөг батлуулан хараат бусаар хийгддэг.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 16,975.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 169.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60.0 хувь буюу 101.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг санхүүгийн байдлын тайлангийн авлага хэсэгт орсон өөрчлөлтийн дагуу шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө болон бараа материалын тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө оны эхнээс 3,664.3 сая төгрөгөөр өссөн нь худалдан авсан 42.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 44.5 сая төгрөгийн тавилга хэрэгсэл, хандиваар 3,541.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 3.7 сая төгрөгийн тавилга хэрэгсэл, 32.7 сая төгрөгийн бусад биет бус хөрөнгө ирсэнтэй холбоотой байна.
- Бараа материал оны эхнээс 42.9 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Коронавируст халдварын үед үзүүлсэн зарим тусламж, үйлчилгээний зардлын төлбөрт өөрчлөлт орсны улмаас ковидын сорьц цуглуулах үйлчилгээ, ПГУ шинжилгээний нийт санхүүжилт болох 751,9 сая төгрөгийг авлагаар тусгууллаа.
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн санхүүжилтийг 2021 оны 12 дугаар 10-ны өдрөөр тасалбар болгосон, ковидын өвчлөл их байсантай холбоотойгоор үүссэн эм, эмнэлгийн хэрэгслийн 1,450.9 сая төгрөгийн өглөгтэй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, ЭМЯ-д нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих 4,993.5 сая төгрөг, улсын төсвөөс санхүүжих 6,941.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 218.6 сая төгрөг нийт зардлыг 12,153.0 сая төгрөгөөр төлөвлөсөн ба Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих 12,080.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 168.0 сая төгрөг нийт санхүүжилт 12,248.5 сая төгрөгөөр батлагджээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсөв 12,248.5 сая төгрөгөөр батлагдаж, Эрүүл мэндийн даатгалын сангаас 9,785.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 1,250.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 201.0 сая төгрөг, Засгийн газрын нөөц сангаас 800.0 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 60.3 сая төгрөгийн санхүүжилт авсан ба тайлант оны нийт төсвийн гүйцэтгэл 12,095.1 сая төгрөг, үлдэгдэл 1.2 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөцөөс 74.1 сая төгрөг, Эрүүл мэндийн яамнаас 543.3 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 401.0 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 0.9 сая төгрөг, нийт 1,019.3 сая төгрөгийн санхүүжилт авч цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 98.1 сая төгрөг, нийгмийн даатгалд төлөх шимтгэл 12.4 сая төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 9.9 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 351.5 сая төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 547.5 сая төгрөгийг тус тус зарцуулжээ зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэхэд нийгмийн даатгалын санд илүү шилжүүлсэн 0.9 сая төгрөгийг санхүүгийн байдлын тайланд авлагаар тусгуулж, үндсэн хөрөнгийн тодруулга тайланд тусгагдаагүй байсан 32.7 сая төгрөгийн хөрөнгийг тусгаж залрууллаа.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулахаас 144 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 55,048.2 сая төгрөгийн зөрчил, хоолны зардлаас байгууллагын ахмадууд хүлээн авах арга хэмжээнд 1,000.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрч албан шаардлага өгсөн бөгөөд биелэлтийг 2021 оны 06 сарын 03-ны өдрийн 101 тоот албан бичгээр ирүүлсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 33.6 сая төгрөгийн алдаа илэрсэн.

4.1 Залруулсан алдаа

Нийгмийн даатгалын санд илүү шилжүүлсэн 0.9 сая төгрөгийг санхүүгийн байдлын тайланд авлагаар тусгасан, үндсэн хөрөнгийн тайлангийн тодруулгад тусгаагүй байсан 32.7 сая төгрөгийн хөрөнгийг тайланд тусган залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

Акт тавигдаагүй.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өвөрхангай аймгийн	1	0.9	1	0.9						
2	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	1	32.7	1	32.7						
	Нийт	2	33.6	2	33.6						

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Э.Энхбаяр

П.Норпил